



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/320

Номгон

Г Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах  
ажлыг эрчимжүүлэх тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох БД 31-112-11" дүрмийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд баригдаж байгаа болон их засвар хийгдэх барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогийг тусгайлан харгалзаж барилгын дотоод орон зай, орчинд нэвтрэн орох, зорчих, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аюулгүй байдлыг хангасан явган хүний зам, налуу зам /пандус/, орц гарц, ариун цэврийн өрөөг MNS6065:2009, MNS6056:2009 стандартууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох БД 31-112-11 дүрмийн дагуу төлөвлөн, хэрэгжүүлж, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлыг эрчимжүүлж ажиллахыг байгууллагын дарга, удирдлагууд, санхүүгийн ажилтнуудад үүрэг болгосугай.

2. Баянхонгор сумын хэмжээнд дэд бүтцийн хүртээмжтэй орчныг бүрдүүлэхээр ажиллаж буй байгууллагуудад мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх "Зөвлөх баг"-ийг байгуулж, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах, хандлагын хүртээмжийг дэмжих чиглэлээр "Жишиг байгууллага шалгаруулах" удирдамж боловсруулж, дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ж.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

3. Дэд бүтцийн хүртээмжтэй орчныг стандартын дагуу хийж гүйцэтгээгүй барилга байгууламжийг улсын комиссоор хүлээн авахгүй байхыг Улсын комиссын гишүүд, ашиглагч байгууллагуудад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642310805